

Арван наймдугаар зүйл

Эрхийн туслалцаа үзүүлэхээс
татгалзах

Хэрэв хусэлт хүлээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн бүрэн эрхт аюулгүй байдалд хохирол учруулахаар байвал эрхийн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

Гуравдугаар бүлэг

Эрхийн асуудлаар мэдээлэх

Арван есдүгээр зүйл

Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын Ийүүх Нам, эсхүл Ерөнхий Прокурор, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн Хуулийн хороо, эсхүл Улсын Прокурор тус тусын хусэлтийн дагуу дагаж журашан байгаа хууль тогтоомж туунийг хэрхэн хэрэглэх тухай асуудлаар харилцан мэдээлж байна*

« Дөрөвдүгээр бүлэг

Бичиг баримт

Хорьдугаар зүйл

Бичиг баримтыг хэрэглэх

1. Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн шуух болон бусад эрх бүхий байгууллагын зохиосон буюу баталсан гарын уезг, сулд бүхий тамгатай бичиг баримтыг Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн шуух болон бусад байгууллагуудад авч хэрэглэхэд өөр баталгаа шаардагдахгүй.

2. Энэ зүйлийн I дэх ангийн заалт шуух болон бусад эрх бүхий байгууллагын баталгаа бүхий бичиг баримтын хуулбарт нэг адил хамаарна.